БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

# “НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк”
ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар

Улаанбаатар хот,
2025 он

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК

# “НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



**УЛААНБААТАР ХОТ**

**2025 ОН**

# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| НЭГ. | НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ..... | 5 |
| ХОЁР. | МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ ..... | 6-13 |
| ГУРАВ. | АЛСЫН ХАРАА ..... | 14 |
| ДӨРӨВ. | ЭРХЭМ ЗОРИЛГО ..... | 14 |
| ТАВ. | ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ ..... | 15-19 |
| ЗУРГАА | СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ..... | 20 |
| ДОЛОО | СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА ..... | 21 |
| НАЙМ. | СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН ..... | 22-28 |
| ЕС. | "НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-ИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ /2024-2028 ОН/ ..... | 29-30 |
| АРАВ. | ГҮЙЦЭТГЭЛИЙН МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭНИЙ МЕХАНИЗМ ..... | 31 |
| АРВАН НЭГ. | ХАВСРАЛТ ..... | 32-34 |

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Хүснэгт 1. | Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн чиг үүрэг .......... | 6 |
| Хүснэгт 2. | Налайхын үйлдвэрлэл, технологийн паркт бусад хууль тогтоомжоор олгогдсон дэд чиг үүрэг .......... | 8 |
| Хүснэгт 3. | Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн холбогдогч талуудын оролцоо /.......... | 11 |
| Хүснэгт 4. | Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн чиг үүргийн хэрэгжилт, хувиар /2024 он/ .......... | 11-13 |
| Хүснэгт 5. | Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн pestle шинжилгээ .......... | 18-19 |
| Хүснэгт 6. | Үйл ажиллагааны төлөвлөгөө .......... | 22-28 |
| Хүснэгт 7. | Стратегийн замын зураглал .......... | 29 |
| Хүснэгт 8. | Стратеги: Менежментийн нэвтрэл (хэрэгцээ) .......... | 30 |

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд холбогдогч талууд ........ 10

Зураг 2. Хүчин зүйлсийн зураглал ........ 17

Зураг 3. Стратегийн зорилго ба бүтцийн уялдаа ........ 22

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль"-ийг 2020 онд шинээр баталсан. Уг хуульд зааснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт зааснаар "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулна" гэж тусгасан.

ЗГХЭГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Аргачлал, загвар батлах тухай" 2020 оны 100 дугаар тушаалд "Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлгийн 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" гэсэн заалтын дагуу Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмыг хэрэгжүүлэх аргачлал, загварчлалыг үндэслэн "Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн стратеги төлөвлөгөө нь эрх зүйн зохицуулалт, хөгжлийн бодлогын баримт бичгүүд, байгууллагын засаглалын үнэлгээний үр дүн, олон улсын аргачлалд тулгуурлан боловсруулагдсан бөгөөд "Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн үндсэн үйл ажиллагаа, бодлого, төлөвлөлт, тогтвортой хөгжилд хүрэх засаглалын системийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжих юм.

## ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь төрийн байгууллагын хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд тусгаснаар "чиг үүрэг" гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл юм.

Паркийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг тус тус мөрдлөг болгосон. Ийнхүү мандатын шинжилгээг дараах алхмуудын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### *Алхам 1.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн чиг үүргийг тодорхойлох*

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасанаар үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологийн цогцолборыг үйлдвэрлэл, технологийн парк /цаашид "парк" гэх/ гэж тодорхойлсон.

Паркийн үйл ажиллагаанд хамаарах ерөнхий болон үндсэн чиг үүргийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд тулгуурлан тодорхойлсон болно. Харин дэд чиг үүргийг тодорхойлохдоо холбогдох хуулиудыг мөрдлөг болгов.

Паркийн чиг үүрэг үйл ажиллагааг зохицуулсан 16 орчим эрх зүйн баримт бичиг (хууль, УИХ-ын тогтоол, НИТХ тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж) байна. Иймд паркийн чиг үүргийг зөвхөн хуульд заасан байдлаар авч үзвэл ерөнхий чиг үүрэг 7, үндсэн чиг үүрэг 14, дэд чиг үүрэг 8 байна. Үүнийг дараах хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харуулав.

*Хүснэгт 1.**НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЧИГ ҮҮРЭГ***

| Д/д | Үндсэн чиг үүрэг | Хуулийн заалт | Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч | |
|---|---|---|---|---|
| | | | Үндсэн хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч |
| Ерөнхий чиг үүрэг 1.Паркийн бүсийг байгуулах, хөгжүүлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах | | | | |
| 1.2 | Хуульд заасанаар паркт байрлах аж ахуйн нэгжүүдийг батлагдсан чиглэлийн дагуу сонгож үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах. | ҮТПЭЗБТХ 4 дүгээр зүйлийн 4.1.2 | НҮТП ХК | |
| 1.2 | Үйлдвэрлэл, технологийн паркийн бодлогын бичиг баримтуудыг боловсруулах батлуулж, мөрдлөг болгох | ҮТПЭЗБТХ 4 дүгээр зүйлийн 4.1.2 | НҮТП ХК | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүрэг - 2: Паркийн дэд бүтцийг хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, хөгжүүлэх, байгуулах | | | | |
| 2.1 | Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх | ҮТПЭЗБТХ 4 дүгээр зүйлийн 4.1.5 | НҮТП ХК | НЗДТГ |
| 2.2 | Паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай зураг төсөв, ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах | ҮТПЭЗБТХ 4 дүгээр зүйлийн 4.1.5 | НҮТП ХК | ХББОСЯ, НЗДТГ |
| Ерөнхий чиг үүрэг - 3: Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх | | | | |
| 3.1 | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.1 | НҮТП ХК | |
| 3.2 | Байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 | НҮТП ХК | |
| Ерөнхий чиг үүрэг - 4: Улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих | | | | |
| 4.1 | Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой импортыг орлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.4 | НҮТП ХК | ААН |
| 4.2 | Улсын болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.4 | НҮТП ХК | НЗДТГ |
| Ерөнхий чиг үүрэг -5. Паркт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлж ажлын байр бий болгох. | | | | |
| 5.1 | Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.5 | НҮТП ХК | НЗДТГ |
| 5.2 | Ажлын байр бий болж бүс нутгаас ажиллах хүч татах | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.5 | НҮТП ХК | НЗДТГ, НДЗДТГ |
| Ерөнхий чиг үүрэг - 6: Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх | | | | |
| 6.1 | Дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.6 | НҮТП ХК | ААН |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.2 | Аюултай хог хаягдлын үйлдвэрийг стандартын дагуу зохион байгуулах | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 5.1.6 | НҮТП ХК | |
| Ерөнхий чиг үүрэг - 7: Бизнесийн таатай орчин бүрдүүлж паркийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | | | | |
| 7.1 | Паркийн нэгжид хуулиар олгогдсон хөнгөлөлт дэмжлэгийг олгох, боловсронгуй болгох санал боловсруулах | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 4.1.1 | НҮТП ХК | НЗДТГ |
| 7.2 | Парк болон паркийн нэгжийн үйл ажиллагааг таниулах, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах | ҮТПЭЗБТХ 5 дугаар зүйлийн 4.1.1 | НҮТП ХК | ААН |

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих үндсэн чиг үүргийнхээ хүрээнд паркийн үйл ажиллагаанд холбогдох зарим дэд чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал; "Компанийн тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Газрын тухай хууль", "Газрын төлбөрийн тухай хууль", "Хөрөнгө оруулалтын тухай хууль", "Төсвийн тухай хууль", "Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрхзүйн байдлын тухай хууль", "Чөлөөт бүсийн тухай хууль", "Усны тухай хууль", "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль", "Барилгын тухай хууль", "Кадастрын тухай хууль" зэрэг хуулиудаар тодорхой дэд чиг үүрэг хүлээсэн байдаг. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй үзүүлэв.

## *Хүснэгт 2.* ***НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-Д БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖООР ОЛГОГДСОН ДЭД ЧИГ ҮҮРЭГ:***

| № | Дэд чиг үүрэг | Хуулийн нэр, заалт | Дэд чиг үүргийг хэрэгжүүлэгч | |
|---|---|---|---|---|
| | | | Үндсэн хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч |
| 1 | Паркийн нэгжүүдэд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг зохион байгуулах | ҮТПЭЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 | НҮТП ХК | |
| 2 | Паркийн удирдлага засаглалыг төлөвшүүлэх | ҮТПЭБТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 13 дугаар | НҮТП ХК | НЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зүйлийн 13.1, 13.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, | | |
| 3 | Паркт байрлах нэгж үйлдвэрүүдэд төлөвлөлтийн дагуу газар сонгон, бичиг баримт бүрдүүлэлтэд хяналт тавих хот байгуулалтын инженерийн байгууламжийн төлөвлөгөөтэй уялдуулан ажиллах | ҮТПЭБТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 11 дүгээр зүйлийн 11.1.3, 13 дугаар зүйлийн 13.3.2, | НҮТП ХК | НЗДТГ |
| 4 | Паркийн дэд бүтцийг хөгжүүлж техникийн нөхцөлүүдийг нарийвчилан судлах | ҮТПЭБТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.7, 3.1.13, 3.1.14 | НҮТП ХК | НЗДТГ |
| 5 | Холбогдох бичиг баримт, материалууд, зураг схемүүдийг бүрдүүлж, паркийн эрчим хүч, дулаан усан хангамжийн хөрөнгө оруулалт татах | Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5, | НҮТП ХК | НЗДТГ |
| 6 | Хүний эрүүл мэнд байгаль орчинд халгүй үйлдвэрлэл нэвтрүүлэх барилгын материалын үйлдвэрлэлийн судалгаа шинжилгээ хийх | ҮТПЭБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.6, Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.12, 4.1.35, | НҮТП ХК | НЗДТГ |
| 7 | Налайх дүүргийн нийгэм, эдийн засаг, ажиллах хүчний судалгаа хийх. | ҮТПЭБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 16 дугаар зүйлийн 16.1.8 | НҮТП ХК | НЗДТГ |
| 8 | Хууль тогтоомж шийдвэрийн биелэлт хангах, олон нийтэд сурталчлах, паркийн хийж байгаа ажлыг олон нийтэд сурталчлах мөн гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож ажиллах | Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.3, 3.1.4, 3.1.5 ҮТПЭБТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.6, 13.4.3, | НҮТП ХК | НЗДТГ |

*Алхам 2.Холбогдогч талууд*

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Налайхын үйлдвэрлэл, технологийн паркаас бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв. Үүнийг ерөнхий байдлаар авч үзвэл Налайхын үйлдвэрлэл, технологийн парк нь

1.Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, паркийн бүсийг хөгжүүлэх талаар санал шийдвэр боловсруулж хүргүүлэх, зөвлөгөө дэмжлэг авах,

2.Хэвтээ чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах,

3.Доошоо чиглэлд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, хүсэлтийг хүлээн авах эргэх холбоогоор хангах, мэдээллээр хангах зэрэг хэлбэрээр харилцаг болно. Паркийн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт үзүүлэв.

*Зураг 1.* ***НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОГЧ ТАЛУУД***



Элгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Өөрөөр хэлбэл Налайхын үйлдвэрлэл, технологийн парк нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ элгээр холбогдогч талуудтай харилцдаг. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 3.* ***НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО***

| Холбогдогч талууд | Оролцоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мэдээлэх | Зөвлөх эргэх холбоогоор хангах | Санал өгөх | Хамтран ажиллах | Шийдвэр гаргах | Хяналт тавих |
| Улсын их хурал | √ | | | | √ | |
| Засгийн газар | √ | √ | | | √ | |
| Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал | √ | √ | | √ | √ | √ |
| Нийслэлийн Засаг дарга | √ | √ | | √ | √ | √ |
| Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | √ | √ | | √ | √ | √ |
| Нийслэлийн Өмчийн харилцааны газар | √ | √ | | √ | √ | √ |
| Яам, агентлаг | √ | √ | | | √ | √ |
| Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар | √ | √ | √ | √ | | |
| Төлөөлөн удирдах зөвлөл | √ | √ | √ | √ | √ | √ |
| Нийслэлийн үйлдвэрлэл, технологийн паркууд | √ | √ | | √ | | |
| Төрийн бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллага | √ | √ | √ | √ | | |
| Аж ахуйн нэгж хувийн хэвшил | √ | √ | √ | √ | | |
| Төрийн бус байгууллага | √ | √ | √ | √ | | |
| Иргэд | √ | | √ | √ | | |

*Алхам 3. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох*

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн ерөнхий болон үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо байгууллагын үйл ажиллагааны тайлан болон Нийслэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийн дүнг үндэслэсэн болно. Дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар үзүүлэв.

*Хүснэгт 4.* ***НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУВИАР /2024 ОН/***

| Д/д | Чиг үүрэг | Чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ | | |
|---|---|---|---|---|
| | | Үйл ажиллагааны тайлан /хувиар/ | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн | Дундаж үнэлгээ /хувиар/ |

| | | | | тайлан /хувиар/ | |
|---|---|---|---|---|---|
| 1 | | Ерөнхий чиг үүрэг-1: Паркийн бүсийг байгуулах, хөгжүүлэх, паркийн нэгжүүдийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах. | 85 | 75 | 80 |
| Үндсэн чиг үүрэг | 1.1 | Хуульд заасны дагуу паркт байрлах аж ахуйн нэгжүүдийг батлагдсан чиглэлийн дагуу сонгож үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах. | 90 | 80 | 85 |
| | 1.2 | Үйлдвэрлэл, технологийн паркийн бодлогын бичиг баримтуудыг боловсруулах батлуулж, мөрдлөг болгох | 80 | 70 | 75 |
| 2 | | Ерөнхий чиг үүрэг-2: Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, хөгжүүлэх, байгуулах | 50 | 45 | 47.5 |
| Үндсэн чиг үүрэг | 2.1 | Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх | 20 | 10 | 15 |
| | 2.2 | Паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай зураг төсөв, ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах | 80 | 80 | 80 |
| 3 | | Ерөнхий чиг үүрэг-3: Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх. | 55 | 50 | 52.5 |
| Үндсэн чиг үүрэг | 3.1 | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх | 50 | 50 | 50 |
| | 3.2 | Байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх | 60 | 50 | 55 |
| 4 | | Ерөнхий чиг үүрэг-4: Улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих | 45 | 45 | 45 |
| Үндсэн чиг үүрэг | 4.1 | Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой импортыг орлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 50 | 50 | 50 |
| | 4.2 | Улсын болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх | 40 | 40 | 40 |
| 5 | | Ерөнхий чиг үүрэг-5: Паркт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлж ажлын байр бий болгох | 65 | 70 | 67.5 |
| Үндсэн | 5.1 | Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 50 | 50 | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 5.2 | Ажлын байр бий болж бүс нутгаас ажиллах хүч татах | 80 | 90 | 85 |
| 6 | | Ерөнхий чиг үүрэг-6: Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх | 80 | 80 | 80 |
| Үндсэн чиг үүрэг | 6.1 | Дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх | 70 | 70 | 70 |
| | 6.2 | Аюултай хог хаягдлын үйлдвэрийг стандартын дагуу зохион байгуулах | 90 | 90 | 90 |
| 7 | | Ерөнхий чиг үүрэг-7: Бизнесийн таатай орчин бүрдүүлж паркийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | 65 | 55 | 60 |
| Үндсэн чиг үүрэг | 7.1 | Паркийн нэгжид хуулиар олгогдсон хөнгөлөлт дэмжлэгийг олгох, боловсронгуй болгох санал боловсруулах | 70 | 60 | 65 |
| | 7.2 | Парк болон паркийн нэгжийн үйл ажиллагааг таниулах, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах | 60 | 50 | 55 |

“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн чиг үүргийн хэрэгжилтийн дундаж үнэлгээг ерөнхий чиг үүргээр багцлан харвал Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх (80%), Паркийн бүсийг байгуулах, хөгжүүлэх, паркийн нэгжүүдийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах (80%) үнэлгээтэй байна. Мөн Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, хөгжүүлэх, байгуулах (47.5%), Улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих (45%) буюу 50-аас доош хувийн үнэлгээтэй байгаа нь цаашид анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

# ГУРАВ. АЛСЫН ХАРАА, УРИА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

## АЛСЫН ХАРАА

***Монгол Улсын барилгын материал, эко технологийн үйлдвэрлэлийг дэлхийн жишигт хүргэж, инновац ба тогтвортой хөгжилд манлайлах үйлдвэр технологийн төв болно.***

# ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, АМБИЦ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

***Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлж, хүний нөөцийн чадавхыг хангаж, барилгын материал үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчинг бий болгож, дотоод зах зээлд тогтвортой хангаж нийлүүлэхийн зэрэгцээ экспортыг нэмэгдүүлнэ.***

## ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ ***Тогтвортой байдал:*** *Ногоон технологи, дахин боловсруулалтыг эрхэмлэх*
- ✓ ***Инновац:*** *Технологийн шинэчлэл, судалгаа-хөгжлийг түргэсгэх*
- ✓ ***Хариуцлага:*** *Байгаль орчин, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах*
- ✓ ***Хамтын ажиллагаа:*** *Олон улсын түншлэл, аж үйлдвэрийн цогцолбор хөгжлийг бэхжүүлэх*
- ✓ ***Ил тод байдал:*** *Менежментийн үйл ажиллагааг нээлттэй, шударга явуулах*

## АМБИЦ

***Налайхын үйлдвэрлэл, технологийн парк нь Монгол Улсын үйлдвэрлэлийн экосистемийг олон улсын түвшинд шинэ шатанд гаргах, мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлтийн хөшүүрэг болно. Бид:***

- ✓ *Азийн тэргүүлэх үйлдвэрлэл, технологийн паркийн загварыг нутагшуулж, бүс нутгийн хэмжээний инновац, кластер хөгжлийн төв болно*
- ✓ *Импортыг орлох, экспортын баримжаатай, өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд суурилсан эдийн засгийн шинэ хөшүүрэг бий болгоно*
- ✓ *Дэд бүтэц, технологи, хүний нөөц, инновацын цогц чадавхыг хөгжүүлсэн загвар паркийн жишиг тогтооно*
- ✓ *Тогтвортой хөгжил, ногоон шийдлийг компанийн соёл бодлогын төвд байршуулна*
- ✓ *Үйлдвэрлэл, судалгаа, бизнесийн хамтын ажиллагааг хөшүүрэг болгон бүтээлч хамтын ажиллагааны орчин бүрдүүлнэ.*

# ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

## 5.1. Гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ

Стратеги төлөвлөгөө боловсруулах баг судалгааны арга зүйн хувьд бодлогын орчинд баримтын судалгаа, стратегийн бэлэн байдлын судалгаа, байгууллагын менежментийн чадамжийг тодорхойлох судалгаа, асуудлын ба зорилгын шинжилгээ,

SWOT шинжилгээ, мексоны шинжилгээ, экспертийн шинжилгээ, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ зэргийг ашиглаж ажлын байран дахь ажиглалт ба ярилцлагын арга болон харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн.

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр байгууллагын төлөв байдалд шинжилгээ, оношилгоо хийх, үнэлгээ өгөх, удирдлагын шийдвэр гаргах, стратегийн төлөвлөгөө боловсруулахад тус дөхөм болохуйц суурь мэдээллийн сан үүсэн болно. Эдгээрийг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад ашиглах болно.

### Гадаад орчны эрсдэлийн үнэлгээ

Байгууллагын гадаад орчны шинжилгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд шууд ба шууд бус нөлөөллийг үзүүлдэг улс төр, эдийн засаг, нийгэм, хүн ам зүй, байршил гадаад хүчин зүйлүүдийн нөлөөллийн ойлголтуудыг хамарч тодорхойлсон.

| № | Гадаад орчноос нөлөөлөх хамгийн аюултай 5 бэрхшээл | Үнэлгээ* |
|---|---|---|
| 1 | Байгаль, уур амьсгалын өөрчлөлт | 5 |
| 2 | Хүн ам зүй, ажиллах хүчний дотоод, гадаад шилжилт хөдөлгөөн | 5 |
| 3 | Үнийн өсөлт, инфляц | 6 |
| 4 | Байгалийн болон цар тахал, бусад давагдашгүй хүчин зүйл | 6 |
| 5 | Тэсрэх бодисын үйлдвэрийн аюулгүйн бүсэд давхацсан байгаа | 5 |
| | **Гадаад орчны эрсдэлийн дундаж үнэлгээ** | **5,4** |

### Дотоод орчны эрсдэлийн үнэлгээ

Байгууллагын дотоод орчны шинжилгээ нь тухайн байгууллагын орц буюу бүх төрлийн нөөцүүд, зохион байгуулж буй үйл ажиллагаа, гарц буюу бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлага, зохион байгуулалт, менежментийн чадамж зэрэг ойлголтуудыг хамарч тодорхойлсон.

| № | Дотоод орчны хамгийн сул 5 хүчин зүйлс | Үнэлгээ* |
|---|---|---|
| 1 | Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сургалт хөгжлийн үйл ажиллагаа хязгаарлагдмал | 6 |
| 2 | Гадаад, дотоод түншлэлийн харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хязгаарлагдмал | 8 |
| 3 | Барилгын бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөт хуваарийн дагуу хийгдэхгүй байгаа | 6 |
| 4 | Төсвийн хөрөнгө оруулалтаас хамаарсан дэд бүтцийн хөрөнгө оруулалт төлөвлөгөөт цаг хугацаанд хийгдэхгүй байгаа | 7 |
| 5 | Паркийн санхүүжилт бага, санхүүгийн баталгаа гаргах боломж муу | 8 |
| | **Дотоод орчны эрсдэлийн дундаж үнэлгээ** | **7,0** |

Урт болон дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад доор дурдсан гадаад орчны аюул, бэрхшээл болон дотоод орчны сул талаас эрсдэл тооцохдоо доорх эрсдэлийн менежментийн матрицын аргачлалыг ашигласан.

### Эрсдэлийн менежментийн матриц

| | | |
|---|---|---|
| 6-Шийдэж болохуйц | 8-Шийдэл хүнд | 9-Шийдэл хүнд |
| 3-Боломжтой | 5-Шийдэж болохуйц | 7- Шийдэл хүнд |
| 1- Боломжтой | 2- Боломжтой | 4-Шийдэж болохуйц |

## 5.2. Эрсдэлийн хариу үйлдлийн төлөвлөлт

Стратеги төлөвлөгөө боловсруулах хүрээнд нь НҮТП-ийн үйл ажиллагаанд шууд ба шууд бус нөлөөлөх микро, макро орчны шинжилгээ хийх, дотоод орчны судалгааг гүйцэтгэж, менежментийн чадамжийн шинжилгээ хийх, орчны нөхцөл байдалд үнэлгээ өгч боломж, бэрхшээл, давуу болон сул талуудыг тодорхойлох, нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр нэгдсэн дүгнэлт гаргаж стратегиудын шийдлийг тодорхойлох зорилтыг дэвшүүлэн ажилласан.

### Эрсдэлийн үнэлгээний нэгтгэл

| № | Эрсдэл | ҮНЭЛГЭЭ |
|---|---|---|
| 1 | Гадаад орчны эрсдэлийн дундаж үнэлгээ | 5,4 |
| 2 | Дотоод орчны эрсдэлийн дундаж үнэлгээ | 7,0 |
| 3 | Эрсдэлийн нэгдсэн дундаж үнэлгээ | 6,2 |

Хүснэгтээс үзвэл, Гадаад орчны эрсдэлийн дундаж үнэлгээ нь 5,4 дотоод орчны эрсдэлийн дундаж үнэлгээ нь 7,0 гэсэн оноогоор илэрхийлэгджээ. Дотоод орчны эрсдэл өндөр, гадаад орчны эрсдлийг шийдэж болохуйц байна.

Эрсдэлийн нэгдсэн үнэлгээнээс харахад **динамик эрсдэлийн ангилалд** багтаж байна. Динамик эрсдэлтэй байгаа нь НҮТП-ийн хөгжлийн стратегийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамт олны хүсэл тэмүүлэл, удирдах зөвлөлийн гишүүд, орон нутгийн удирдлагын дэмжлэг нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд давуу талыг ашиглаж боломжийг хүртэх замаар эрсдэлээс зайлсхийж, сул талыг давуу тал болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хариу үйлдлийг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

## Хүчин зүйлсийн зураглалын шинжилгээ

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн менежментийн чадамжийн шинжилгээний явцад гадаад дотоод орчныг шинжилж 18 **боломж, 10 аюул бэрхшээл**, дотоод орчны **14 давуу тал, 15 сул талыг** асуудлын болон зорилгын модны шинжилгээ, SWOT шинжилгээний үр дүнгээр нийт **57** хүчин зүйлсийг тодорхойлсон.

Зураг 2

### Хүчин зүйлсийн зураглал



Эдгээр хүчин зүйл тус бүр дээр экспертийн шинжилгээ хийж үзэхэд гадаад орчны нөлөөлөл 49.1 хувь, дотоод орчны нөлөөлөл 50.9 хувь байна.

| Нөлөөлөл | Тоо | Хувь | |
|---|---|---|---|
| Давуу тал | 14 | 24.6 | 50.9 |
| Сул тал | 15 | 26.3 | |
| Боломж | 18 | 31.6 | 49.1 |
| Аюул | 10 | 17.5 | |
| Хүчин зүйлс | 57 | 100.0 | |

Дүгнэвэл дотоод орчны хүчин зүйл ихтэй байгаа нь стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ҮТП-ийн удирдлага, хамт олны оролцоо маш их байгааг илтгэж байна.

Стратегийн томъёоллын зураглалаас харвал **"БОЛОМЖИЙГ ХҮРТЭЖ, ДАВУУ ТАЛЫГ АШИГЛАХ ЗАМААР ХҮНИЙ БОЛОН САНХҮҮГИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ"** чиглэлд зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх удирдлагын тактик ашиглах нь зүйтэй.

А.Х.Мексоны "5Х5" шинжилгээний үр дүнд тулгуурлаж "Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн бизнесийн орчин, зах зээлийн төлөв байдалд хамгийн чухал 25 хүчин зүйлсийг сонгон хөгжилд хүрэх зорилго, зорилтыг экспертийн шинжилгээнд тулгуурлан тодорхойлов.

## 5.3. Стратегийн гол зорилтыг тодорхойлох мексоны 5х5 шинжилгээ

А.Х.Мексоны "5Х5" шинжилгээний үр дүнд тулгуурлаж хамгийн чухал 25 хүчин зүйлсийг сонгон авч нэн тэргүүн шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, хөгжлийн стратегийг тодорхойлж байна.

### Мексоны асуулт 1. Хамгийн их нөлөөлөх гадаад орчны 5 боломж

1.1 "Тогтвортой хөгжлийн зорилт-2030" нийгэм, эдийн засаг, байгаль орчин бүхий гурван тулгуурт суурилсан тогтвортой хөгжилд хүрэх бодлогын баримт бичиг
1.2 Импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэл
1.3 Монгол улсад аж үйлдвэрийн салбарын хоцрогдсон технологийг халж хөгжлийн шинэлэг чиг хандлага
1.4 Барилгын материалын салбарт шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологи
1.5 Төрөөс барилгын салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2019-2029/-ний зорилт 2-т салбарын шинжлэх ухаан технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээг бий болгохоор тусгасан.

### Мексоны асуулт 2. Гадаад орчноос нөлөөлөх хамгийн аюултай 5 эрсдэл

2.1 **Байгаль, уур амьсгалын өөрчлөлт**
2.2 **Хүн ам зүй, ажиллах хүчний дотоод, гадаад шилжилт хөдөлгөөн**
2.3 Удирдах дээд байгууллагаас гарах хууль тогтоомж, захирамж Байгаль хамгаалын хязгаарлалтууд
2.4 Байгалийн болон цар тахал, бусад давагдашгүй хүчин зүй
2.5 Тэсрэх бодисын үйлдвэрийн аюулгүйн бүстэй давхацсан байгаа

### Мексоны асуулт 3. Дотоод орчны хамгийн давуу 5 хүчин зүйлс

3.1 Үйлдвэр барихад шаардлагатай дэд бүтэц бүхий суурь бааз байгуулагдаж ашиглалтад орсон
3.2 Паркийн дэд бүтцийг байгуулж, үйлдвэрүүд баригдах суурь нөхцөл бүрдсэн
3.3 Үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлүүд батлагдан, газар зохион байгуулалт хийгдсэн

3.4 Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн босоо тэнхлэгээс салаалсан 4.64 км хуцад дааиын бетон авто замаар холбогдсон
3.5 Үйлдвэрлэл технологийн парк, түүний үйл ажиллагаа олон нийтэд танигдсан

### Мексоны асуулт 4. Дотоод орчны хамгийн сул 5 хүчин зүйлс

4.1 Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сургалт хөгжлийн үйл ажиллагаа хязгаарлагдмал
4.2 Гадаад, дотоод түншлэлийн харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хязгаарлагдмал
4.3 Барилгын бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөт хуваарийн дагуу хийгдэхгүй байгаа
4.4 Төсвийн хөрөнгө оруулалтаас хамаарсан дэд бүтцийн хөрөнгө оруулалт төлөвлөгөөт цаг хугацаанд хийгдэхгүй байгаа
4.5 Паркийн санхүүжилт бага, санхүүгийн баталгаа гаргах боломж муу

## 5.4. Хамгийн чухал гэж сонгосон SWOT шинжилгээний 5 хүчин зүйлс:

5.1 "Тогтвортой хөгжлийн зорилт-2030" нийгэм, эдийн засаг, байгаль орчин бүхий гурван тулгуурт суурилсан тогтвортой хөгжилд хүрэх бодлогын баримт бичиг
5.2 Байгаль, уур амьсгалын өөрчлөлт
5.3 Хүн ам зүй, ажиллах хүчний дотоод, гадаад шилжилт хөдөлгөөн
5.4 Үйлдвэр барихад шаардлагатай дэд бүтэц бүхий суурь бааз байгуулагдаж ашиглалтад орсон
5.5 Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сургалт хөгжлийн үйл ажиллагаа хязгаарлагдмал

## 5.5.Гадаад орчны шинжилгээ

### PESTLE шинжилгээ

Макро орчин нь үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаанд эерэг, сөрөг байдлаар нөлөөлдөг. Нөлөөлөх хүчин зүйлсийг судлан шинжлэх хэд хэдэн аргууд байдаг. Үүний нэг нь PESTLE шинжилгээний арга юм. PESTLE шинжилгээний арга нь:

- Political force буюу Улс төр-хууль эрхзүйн орчин
- Economic force буюу Эдийн засгийн орчин
- Sociocultural force буюу Нийгэм-соёлын орчин
- Technological force буюу Техник технологийн орчин
- Legal force буюу Хууль эрхзүйн хүчин зүйл
- Environmental force буюу Хүрээлэн буй орчны хүчин зүйл гэсэн үгнүүдийн товчлол юм.

*Хүснэгт 5. НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН PESTLE ШИНЖИЛГЭЭ*

| | ХҮЧИН ЗҮЙЛС | ҮЗҮҮЛЭЛТ | ТАЙЛБАР |
|---|---|---|---|
| P | Улс төр | - Улс төрийн тогтвортой байдал<br>- Үнийн зохицуулалт<br>- Татварын бодлого | - Газрын төлбөрийн тухай хуулийн 8.1.9 дэх хэсэгт заасны дагуу паркийн газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг газар эзэмших, ашигласны төлбөрөөс 10 жил чөлөөлнө.<br>- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн 7.1.4-ийн дагуу паркийн үйлдвэрийн барилга, байгууламж бусад үл хөдлөх хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлнө. |
| E | Эдийн засаг | - Инфляц<br>- Аж ахуйн нэгжүүдийн тоо | - НҮТП нь 64 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа. |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Эдийн засгийн өсөлтийн хувь<br>- Ажилгүйдэл<br>- Зээлийн хүүгийн түвшин | - АХБ Монгол Улсын 2020 оны эдийн засгийн өсөлтийг 2019 оны гүйцэтгэл 5.1%-иас мэдэгдэхүйц буурч 2.1%, 2021 онд 4.6% байхаар төсөөлжээ.<br>- МУ-ын эдийн засгийн өсөлт 2020 онд -5.3%<br>- 1 их наяд хөтөлбөрийн хүрээнд жилийн гурван хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай 2 их наяд төгрөгийн зээл |
| S | Нийгмийн | - Хүн амын өсөлт, хүйсийн бүтэц<br>- Эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого | - Налайхын хүн амын суурийн 3 жилийн дундаж өсөлт 2.7%, нийт хүн амд эрэгтэй 48%, эмэгтэй 52% эзэлж байна.<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008 он<br>- "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS OHSAS 18001:2012" стандарт |
| T | Техникийн | - Мэдээллийн технологи, интернэтэд гарч буй өөрчлөлтүүд<br>- Технологийн өөрчлөлтийн түвшин | - Төрөөс барилгын салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2019-2029/-ний зорилт 2-т салбарын шинжлэх ухаан технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж эрэлт шинжилгээ, судалгаанд суурилсан инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээг бий болгохоор тусгасан. |
| L | Хуулийн | - Холбогдох хууль эрх зүйн баримт | - Хот байгуулалтын тухай хууль 2008 он<br>- Газрын тухай хууль 2002 он<br>- Барилгын тухай хууль 2016 он<br>- Эрүүл ахуйн тухай хууль 2016 он<br>- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 2009 он<br>- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль 2022 он |
| E | Байгаль орчны | - Цаг уур, уур амьсгалын өөрчлөлт<br>- Байгаль хамгааллын бодлого<br>- Төрийн бус байгууллагын санал | - Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, 1997 он<br>- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр 2011 он<br>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09 |

# ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК нь 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг болно.

*Зураг 3.* ***СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА***




Дээрх зураглалын дагуу байгууллагын албан хаагч бүр хоорондын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг эрхэмлэн стратегийн зорилгын биелэлтийг хангахын тулд өөрсдийн үндсэн үүргийн хүрээнд ажиллана. Мөн Нийслэлийн харьяа байгууллага, нэгж, аж ахуйн нэгжүүдтэй харилцан уялдаа холбоотой хамтын ажиллагаатай байна. Дэлгэрэнгүй хэлбэрээр харуулав.

## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дараах хэсэгт харуулав.

*Хүснэгт 6. **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ***

| Зорилт | Арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Стратегийн зорилго 1: ПАРКИЙН САНХҮҮ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО** | | | | | |
| *Зорилт 1.1 Удирдлага, засаглалыг төловшүүлэх* | 1.1.1.Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, дүгнэх | Боловсруулагдсан баримт бичгийн тоо, хэрэгжилт | 0 | 3 | Нийслэлийн төсөв |
| | 1.1.2.Паркийн үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм, журмын төслийг боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлэн батлуулах | Хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх | 0 | 2 | Нийслэлийн төсөв |
| | 1.1.3.Иргэд, албан хаагч, ажилтан, түнш, захиргааны болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, санаачилгыг олон сувгаар цуглуулж, бодит шийдвэрт тусгах тогтолцоог бүрдүүлэх | Санал санаачилга бодит шийдвэрт тусгагдсан эсэх | 0 | 3 | Нийслэлийн төсөв |
| | 1.1.4.Сонирхогч талуудын хувь нэмрийг үнэлж, хүлээлтийг хангах үр дүнг салбарын жишигтэй харьцуулж, стратегийн шийдвэр гаргалтад нэгтгэх | Стратегийн шийдвэр гаргалтад нэгтгэгдсэн эсэх | 0 | 3 | Нийслэлийн төсөв |
| | 1.1.5.Өөрчлөлтийн удирдлагын календарь, хяналтын цэг, үр нөлөө үнэлэх шалгуур бүхий албан ёсны журам мөрдүүлэх | Журам гарсан эсэх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| *Зорилт 1.2 Санхүүгийн төлөвлөгөө, тайлагнал, хяналтыг сайжруулах, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх* | 1.2.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж, мэдээллийн ил тод байдлыг хангах | Төсвийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх | 100% | 100% | Нийслэлийн төсөв |
| | 1.2.2.УТПЭБТХ-ийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу паркийн орлогыг бүрдүүлж, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах | Төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх | 0 | 100% | Нийслэлийн төсөв |
| | 1.2.3.KPI болон харьцуулсан үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, дэлгэрэнгүй тоо судалгаа гарган явуулах, хяналт, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | Хяналт шалгалт тогтмол хийгддэг эсэх | 30% | 100% | Нийслэлийн төсөв |
| *Зорилт 1.3 Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх* | 1.3.1.Чадамжид суурилсан хүний нөөцийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх | Стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн эсэх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |
| | 1.3.2.Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 3 | Нийслэлийн төсөв |
| | 1.3.3.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 5 | Нийслэлийн төсөв |
| | 1.3.4.Удирдах ажилтнуудын манлайлал, хариуцлагын хөтөлбөр хэрэгжүүлэх | Удирдлагын гүйцэтгэл, шийдвэрийн чанар | 70% | 100% | Нийслэлийн төсөв |
| | 1.3.5.Урамшуулал, карьер хөгжлийн шатлалт тогтолцоо бүрдүүлэх | Ажилтнуудын тогтвортой байдал, бүтээмж | 40% | 100% | Нийслэлийн төсөв |
| | 1.3.6.Үүрэг даалгаврын менежментийг сайжруулж, ажлын ачааллыг тэнцвэржүүлнэ | Ажлын ачаалал тэнцсэн эсэх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |
| | 1.3.7.Хамт олны дундах эерэг соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх | Байгууллагын соёлыг таниулсан эсэх | 50% | 100% | Нийслэлийн төсөв |
| | 1.3.8.Гүйцэтгэлийн үнэлгээний системийг бий болгох | Шагнал урамшуулал, хариуцлагын систем бий болсон эсэх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |
| **Стратегийн зорилго 2: ПАРКИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БҮСЧЛЭЛИЙГ БИЙ БОЛГОХ** | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 2.1. Паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх*** | 2.1.1.Паркийн 120 га газрыг дэд бүтцээр бүрэн хангах ажлыг зохион байгуулж ашиглалтад авах | ХЕТ-ийн дагуу дэд бүтцээр бүрэн хангагдсан эсэх | 20% | 70% | Улс, нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 2.1.2.Төмөр замын терминал бүхий логистикийн дэд бүтэц, төлөвлөлтийг боловсруулах | Төлөвлөлт хийгдсэн эсэх | 10% | 100% | Улс, нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 2.1.3.Паркийн 120га, 130га, 60га, 50га газрын нэгдсэн Техник эдийн засгийн үндэслэл хийлгэх | ТЭЗҮ хийгдсэн эсэх | 10% | 100% | Улс, нийслэлийн төсөв |
| | 2.1.4.Шинжилгээ судалгааны төвийн зураг төслийг боловсруулах | Зураг төсөл хийгдсэн эсэх | 0 | 100% | Улс, нийслэлийн төсөв, ТХХТ |
| ***Зорилт 2.2. Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах*** | 2.2.1.Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулж, шийдвэрлүүлэх | Төсөвт тусгагдсан эсэх | 20% | 100% | Улс, нийслэлийн төсөв |
| | 2.2.2.Олон улсын байгууллага, хөтөлбөртэй хамтран ажиллах, уулзалт зохион байгуулах, оролцох | Хөрөнгө оруулалт хийгдсэн эсэх | 0 | 1 | Улс, нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 2.2.3.Орон нутгийн засаг захиргаа, төрийн агентлагуудтай стратегийн уялдаатай хамтран ажиллах бодлого хэрэгжүүлэх | Хамтын ажиллагаа өргөжсөн эсэх | 0 | 3 | Улс, нийслэлийн төсөв |
| | 2.2.4.Хөрөнгө оруулалтыг татах маркетинг, менежментийн ажлыг зохион байгуулах | Хөрөнгө оруулалт хийгдсэн эсэх | 0 | 2 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| ***Зорилт 2.3. Худалдаа үйлчилгээний бүс байгуулах*** | 2.3.1.Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах. | ХЕТ боловсруулан батлагдсан эсэх | 0 | 100% | Төр хувийн хэвшлийн түншлэл |
| | 2.3.2.Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийг барьж, байгуулах ажлыг эхлүүлэх | Ажлын явц, гүйцэтгэл | 0 | 50% | Нийслэлийн төсөв, ТХХТ |

**Стратегийн зорилго 3: БҮС НУТГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД**

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| *Зорилт 3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих* | 3.1.1.Нийслэлийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах | Ажлын байраар хангасан иргэдийн тоо | 168 | 400 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 3.1.2.Их, дээд сургууль мэргэжил олгох сургалт үйлдвэрийн төвүүдтэй хамтарсан "Үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөр" хэрэгжүүлэх | Бэлтгэгдсэн ажиллах хүчний тоо | 0 | 30 | Төр хувийн хэвшлийн түншлэл |
| | 3.1.3.Паркийн сургалт, судалгаа, инновацын технологийн цогцолбор барих төслийг эхлүүлэх | Ажлын явц, гүйцэтгэл | 0 | 30% | Төр хувийн хэвшлийн түншлэл |
| | 3.1.4.Ажлын байрны өдөрлөгийг зохион байгуулах, оролцох | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 10 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| *Зорилт 3.2. Бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих* | 3.2.1.Налайх дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжиж ажиллах | ААН-д НД-ийн татварын хэлтэст бүртгүүлсэн эсэх, орон нутгаас ажиллах хүчнийг авсан эсэх | 10% | 80% | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 3.2.2.Налайх дүүргийн ЗДТГ-с зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд ААНБ-ыг татан оролцуулж дэмжин ажиллах | Үйл ажиллагаанд оролцсон тоо | 0 | 6 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 3.2.3.Өдөр тутмын үйл ажиллагаанд хүртээмж, тэгш байдал, зорилтот бүлэгт үзүүлэх үйлчилгээг тасралтгүй сайжруулах | Орчин бүрдүүлсэн эсэх | 0 | 80% | Нийслэлийн төсөв |
| **Стратегийн зорилго 4: БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙ, НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД** | | | | | |
| *Зорилт 4.1. Өндөр технологид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин байгаль орчинд ээлтэй, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэвтрүүлэх* | 4.1.1.Дэвшилтэт технологид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих | Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо | 2 | 10 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 4.1.2.Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлогыг тодорхойлох, зах зээлд нэвтрүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх | Шинэ бүтээгдэхүүний тоо хэмжээ | 0 | 5 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 4.1.3.Барилгын материалын туршилт баталгаажуулалтын лаборатори чанарын баталгаажуулалт авах | Баталгаажуулалт хийгдсэн бүтээгдэхүүний тоо | 0 | 10 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 4.1.4.Экспортын зориулалттай бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх | Гэрчилгээ авсан бүтээгдэхүүний тоо | 0 | 5 | Нийслэлийн төсөв, ТХХТ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| *Зорилт 4.2. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх* | 4.2.1. Дахивар түүхий эдийг дахин боловсруулах, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэлийг байгуулах | Үйлдвэрийн тоо | 1 | 5 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 4.2.2.Ангилан ялгах хаягдлын нэгдсэн журам баталж хэрэгжүүлэх | Ангилсан хог хаягдлын эзлэх хувь | 0 | 70% | Нийслэлийн төсөв |
| | 4.2.3.Гэрэлтүүлэг, камер, хог ангилан хаях ухаалаг хогийн сав бүхий ногоон орчны систем суурилуулах | Суулгасан төхөөрөмжийн тоо | 0 | 5 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| **Стратегийн зорилго 5: ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА, МАРКЕТИНГ СУРТАЛЧИЛГААГ ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | |
| *Зорилт 5.1. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх* | 5.1.1.Олон улсын барилгын материалын үзэсгэлэнд оролцох | Үйл ажиллагааны тоо | 0 | 3 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 5.1.2.НҮТП-ийн гадаад сурталчилгааны вэбсайт, мультимедиа контент, олон хэл дээрх каталог хөгжүүлэх | Хандалтын тоо | 0 | 5000 | Нийслэлийн төсөв |
| | 5.1.3.Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зөвлөгөөн зохион байгуулах. | Зохион байгуулсан уулзалт зөвлөгөөний тоо | 0 | 10 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 5.1.4.Барилгын томоохон төсөл, хот байгуулалтын байгууллагуудтай урт хугацааны гэрээ байгуулах | Гэрээ байгуулсан тоо | 0 | 3 | Нийслэлийн төсөв |
| | 5.1.5.Монголын дипломат төлөөлөгчийн газар, худалдааны танхимуудтай хамтран ажиллах | Арга хэмжээний тоо | 0 | 3 | Нийслэлийн төсөв |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| *Зорилт 5.2. Маркетинг сурталчилгааг хөгжүүлэх* | 5.2.1.Паркийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, товхимол, сэтгүүл, видео бичлэг, хэвлэмэл болон дижитал материалуудыг бэлтгэж түгээх, ил тод байдлыг хангах | Танилцуулах материалын тоо | 0 | 10 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 5.2.2.ҮТП-д байрших үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх | Арга хэмжээний тоо | 0 | 5 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 5.2.3. Улаанбаатар хотын иргэд болон Налайх дүүргийн иргэд олон нийтэд чиглэсэн өдөрлөг, уулзалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулж паркийн үйл ажиллагааны талаар мэдээллээр хангах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /жилд/ | 0 | 2 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| **Стратегийн зорилго 6: ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ТУЛГУУРЛАСАН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | |
| *Зорилт 6.1. Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна* | 6.1.1.Стратеги төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөгөөтэй уялдуулах | Хөгжлийн төлөвлөгөөний дунд хугацааны зорилго, стратегийн биелэлтийн хувь | 0 | 30% | Нийслэлийн төсөв |
| | 6.1.2.Байгууллагын алсын хараа, зорилгыг улс нийслэл, бүс нутгийн урт, дунд хугацааны бодлого, чиглэлтэй уялдуулан тогтмол сайжруулах | Бодлогын бичиг баримттай уялдуулсан эсэх | 50% | 80% | Нийслэлийн төсөв |
| *Зорилт 6.2. Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ* | 6.2.1.Парк, паркийн нэгжүүдийн хамт олны дунд зэрэг, идэвхжүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 8 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 6.2.2.Удирдлага болон албан хаагчид ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн байгууллагын соёлыг хэвшүүлэх | Байгууллагын соёлын судалгааны дүгнэлт | 0 | 4 | Нийслэлийн төсөв |
| | 6.2.3.Албан хаагчийн ёс зүй, хандлага, өөрийгөө хөгжүүлэх, чанартай бүтээмжийг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх, урамшуулах тогтолцоог хэвшүүлэх | Үнэлгээ, урамшууллын тогтолцоог бүрдүүлсэн эсэх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 6.3. Оролцогч талуудын оролцоог хангана*** | 6.3.1.Паркийн нутаг дэвсгэрийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж аюулгүй байдлыг хангах, хаягийн нэгдсэн стандартыг мөрдүүлэх | Гэрэлтүүлэг, камерийн байршил | 0 | 15 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | | Стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх | 0 | 20 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 6.3.2.Паркийн нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, нэгжүүдийн оролцоог хангах | Ногоон байгууламж хийгдсэн нийт талбайн хэмжээ | 0 | 1га | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| | 6.3.3.Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад нээлттэй бодлого баримталж төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх | Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тоо | 0 | 2 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| ***Зорилт 6.4. Тогтвортой үнэ цэнийг бий болгоно*** | 6.4.1.MNS ISO9000:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх | Гэрчилгээ авсан байх | 0 | 1 | Нийслэлийн төсөв |
| | 6.4.2.Паркийн аж ахуйн нэгжүүдийг кластер байдлаар зохион байгуулах | Кластер үйлдвэрүүдийн тоо | 0 | 3 | Нийслэлийн төсөв, ТХХТ |
| ***Зорилт 6.5. Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт*** | 6.5.1.Байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх | парк болон паркийн нэгжийн гүйцэтгэлийн хувь, чанар | 0 | 80% | Нийслэлийн төсөв |
| | 6.5.2.Мэдээллийн хүртээмжтэй байдлын судалгааг авч дүгнэх, сайжруулалтын арга хэмжээ зохион байгуулах | Жилд 1 удаа тогтмол хийдэг эсэх | 0 | 4 | Нийслэлийн төсөв |
| ***Зорилт 6.6. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх*** | 6.6.1.Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, дүгнэлтийн мөрөөр сайжруулалтын арга хэмжээг зохион байгуулах | Жилд 1 удаа тогтмол хийдэг эсэх | 0 | 4 | Нийслэлийн төсөв |
| | 6.6.2.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, дүн шинжилгээ хийх | Хэрэгжилтийн үнэлгээг жилд 1 удаа тогтмол хийдэг эсэх | 0 | 4 | Нийслэлийн төсөв |

## ЕС. СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ

*Хүснэгт 7.* ***СТРАТЕГИЙН ЗАМЫН ЗУРАГ***

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| АЛСЫН ХАРАА | Монгол Улсын барилгын материал, эко технологийн үйлдвэрлэлийг дэлхийн жишигт хүргэж, инновац ба тогтвортой хөгжилд манлайлах үйлдвэр технологийн төв болно. | | | | |
| | **"СТАНДАРТТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН ХӨГЖИЛ"** | | | | |
| ЭРХЭМ ЗОРИЛГО | Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологи нэвтрүүлж, хүний нөөцийн чадавхыг хангаж, барилгын материал үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчинг бий болгож, дотоод зах зээлд тогтвортой хангаж нийлүүлэхийн зэрэгцээ экспортыг нэмэгдүүлнэ. | | | | |
| | **Тогтвортой байдал, инновац, хариуцлага, хамтын ажиллагаа, ил тод байдал** | | | | |
| **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ** | **Удирдлага** | **Дэд бүтэц** | **Эдийн засаг** | **Байгаль орчин** | **Хамтын ажиллагаа** |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО** | Паркийн санхүү, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх | Паркийн дэд бүтцийг хөгжүүлэх, бүсчлэлийг бий болгох | Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих | Байгаль орчинд халгүй, ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Гадаад харилцаа хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааг хөгжүүлэх |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛТ** | 1.1. Удирдлага, засаглалыг төлөвшүүлэх.<br>1.2. Санхүүгийн төлөвлөгөө, тайлагнал, хяналтыг сайжруулах, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх<br>1.3. Паркийн хөгжлийг хангахуйц хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ. | 2.1. Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх<br>2.2. Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах<br>2.3. Худалдаа үйлчилгээний бүс байгуулах | 3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих<br>3.2. Налайх дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих | 4.1. Өндөр технологид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин байгаль орчинд халгүй, хаягдалгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэвтрүүлнэ.<br>4.2. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх | 5.1. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх<br>5.2. Маркетинг сурталчилгааг хөгжүүлэх |
| **ҮР ДҮНГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | |
| Дэвшилтэт техник, технологи, инновацыг барилгын материал үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлнэ. | | | Импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх бизнесийн таатай орчин бүрдүүлсэн жишиг үйлдвэрлэл технологийн парк болно. | | |

*Хүснэгт 8. **СТРАТЕГИ: МЕНЕЖМЕНТИЙН НЭВТРЭЛТ, (ХЭРЭГЦЭЭ)***

| | МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛҮҮД | Удирдлага | Дэд бүтэц | Эдийн засаг | Байгаль орчин | Хамтын ажиллагаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Төлөвлөлт** | | | | | |
| 1.1 | Стратегийн удирдлага | ■ | | | | |
| 1.2 | Хөтөлбөрийн удирдлага | | | | | ■ |
| 1.3 | Төслийн удирдлага | | ■ | | | |
| 1.4 | Маркетингийн удирдлага | | | ■ | | |
| 1.5 | Брэндийн удирдлага | | | | | |
| 1.6 | Мэдлэг, инновацын удирдлага | | | | ■ | |
| 1.7 | Харилцаа хамтын ажиллагааны удирдлага | | | | | |
| 1.8 | Гэрээний удирдлага | | | | | ■ |
| 1.9 | Эрсдэлийн удирдлага | ■ | | | | |
| 1.10 | Шийдвэр гаргалтын удирдлага | | | ■ | | |
| 2 | **Зохион байгуулалт** | | | | | |
| 2.1 | Системийн удирдлага | | | ■ | | |
| 2.2 | Үйлдвэрлэл үйл ажиллагааны удирдлага | ■ | | | | |
| 2.3 | Амьдралын мөчлөгийн удирдлага | | | | | |
| 2.4 | Сүлжээний удирдлага | | | | | ■ |
| 2.5 | Технологийн удирдлага | | ■ | | | |
| 2.6 | Олон нийтийн харилцааны удирдлага | | | | | ■ |
| 2.7 | Хэрэглэгчийн харилцааны удирдлага | | | | ■ | |
| 2.8 | Хөрөнгө оруулалтын удирдлага | ■ | | | | |
| 2.9 | Мэдээлэл технологийн удирдлага | | | ■ | | |
| 2.10 | Логистик удирдлага | | ■ | | | |
| 3 | **Манлайлал** | | | | | |
| 3.1 | Чадамжийн удирдлага | | ■ | | | |
| 3.2 | Хүний нөөцийн удирдлага | ■ | | | | |
| 3.3 | Суралцагч байгууллагын удирдлага | | | | | |
| 3.4 | Мэдлэгийн удирдлага | | | ■ | | |
| 3.5 | Ур чадварын удирдлага | | | | | |
| 3.6 | Стрессийн удирдлага | | | | | |
| 3.7 | Хувь хүний удирдлага | | | | | |
| 3.8 | Карьер удирдлага | | | | | |
| 3.9 | Багийн удирдлага | | | | | ■ |
| 3.10 | Санал гомдлын удирдлага | | | | ■ | |
| 4 | **Хяналт** | | | | | |
| 4.1 | Засаглалын удирдлага | ■ | | | | |
| 4.2 | Бүтээмжийн удирдлага | | | | | |
| 4.3 | Гүйцэтгэлийн удирдлага | | | | | ■ |
| 4.4 | Чанарын удирдлага | | | | ■ | |
| 4.5 | Санхүүгийн удирдлага | | | ■ | | |
| 4.6 | Өртөг зардлын удирдлага | | ■ | | | |

## АРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН МОНИТОРНГ, ҮНЭЛГЭЭНИЙ МЕХАНИЗМ

### 10.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах

НҮТП-ийн бүтэц, зохион байгуулалтыг чиг үүргийн хүрээнд сайжруулах нь энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үгтвар нөхцөл болох юм. Хэлтэс, нэгжийн оролцоотойгоор үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд түшиглэн дунд болон богино хугацааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, биелэлтийг хангаж ажиллана.

Стратеги, бодлого төлөвлөлт хариуцсан нэгж, албан тушаалтан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хоёр жил тутам нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ. Хэрэгжилтийн тайланд дараах зүйлсийг тодорхой тусгана

10.1.1. Төлөвлөсөн үр дүн буюу зорилго, зорилтот түвшин;

10.1.2. Төлөвлөгөөнд туссан зорилго, зорилтын биелэлт (төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх);

10.1.3. Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл.

НҮТП-ийн захиргаанаас стратеги төлөвлөгөөний хүрээнд газар, нэгжийг бодлогын удирдлагаар хангаж, стратегийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд үндэслэн жил бүр газар, нэгжийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлнэ.

### 10.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх

Стратеги төлөвлөгөө, түүнтэй холбогдох хөтөлбөр, төслүүдийг боловсруулах ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан менежер Гүйцэтгэх захирлын өмнө хариуцан ажиллана.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор баталсан "Үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу жил тутам үнэлж, тайлагнана.

Төсвийн ерөнхийлөн захирагч (салбарын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга) стратеги төлөвлөгөөний тухайн жилийн хэрэгжилтийн үнэлгээнд үндэслэн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаагүй зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжүүлнэ.

# АРВАН НЭГ.ХАВСРАЛТ

## 11.1.Хамт олны чадамжийн өөрийн үнэлгээний судалгааны тойм

Судалгааг ОУХБ-ын ПС стратегийн дизайн боловсруулах, тогтолцооны чанарыг үнэлэх аргачлал болон Удирдлагын академийн "Бизнесийн болон төрийн байгууллагын менежментийн чадамжийн ерөнхий төлөв"-ийг тодорхойлсон судалгаа, магадлан итгэмжлэлийн чанарын баталгаажилтын хийх аргачлал зэргийг ашиглан "Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн менежментийн чадамжийн өөрийн үнэлгээг 5 бүлгийн холбогдох шалгуур үзүүлэлтээр **"Google form"** ашиглан мэдээллийг цуглуулж статистик боловсруулалт хийсэн.

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн стратеги төлөвлөгөө боловсруулах 2024 оны байдлаар менежментийн ерөнхий чадамжид бойжигч ААНБ-с авсан судалгааны дундаж үнэлгээ 66 хувь буюу САЙН (-) дүнтэй гарсан байна.

График 1




Дээрх графикаас харахад захиргаа ба удирдлага 77.7 хувь буюу сайн. Харин бусад 4 үндсэн үзүүлэлт 61.1-67.7 хувийн хооронд сайн (-) хэмээн үнэлэгдсэн байна.

| | | |
|---|---|---|
| 1 | Захиргаа ба удирдлага | Сайн |
| 2 | Байгууллагын үйл ажиллагаа | Сайн (-) |
| 3 | Хүний нөөцийн чадавх | Сайн (-) |
| 4 | Мэдлэг, инновацын чадавх | Сайн (-) |
| 5 | Санхүүгийн нөөц ашиглалтын чадавх | Сайн (-) |
| | ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | Сайн (-) |

Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль

болон холбогдох журам, дүрмийн хүрээнд техникийн болон мэргэжлийн боловсролын ААНБ-ын үйл ажиллагааг Улаанбаатар хот төдийгүй үндэсний хэмжээнд жишиг үйлдвэрлэл технологийн парк байдлаар хөгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн бойжигч ААНБ-с өгсөн байгууллагын ерөнхий чадамжийн ерөнхий үнэлгээ 66.0 хувь буюу "САЙН (-)" гэж үнэлэгдсэн байна.

Иймд Налайх ҮТП-ийн үйл ажиллагаанд бий болсон захиргаа ба удирдлага, үйл ажиллагаа, мэдлэг, инновацын хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагаанд тулгуурлан санхүүгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор үйл ажиллагааны орлого олох, гүйцэтгэлд суурилсан олон эх үүсвэрт санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх, бойжигч ААНБ-ын тоо хэмжээг нэмэгдүүлэх хөгжлийн зорилт, зорилгуудыг тодорхойлох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Стратегийн удирдлагын дэвшилтэт шинэ арга хэрэгслийг эзэмшин өрсөлдөх чадвараа бэхжүүлэх арга хэмжээ авч гадаад харилцааны цар хүрээг өргөжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд Нийслэлийн бүс болон үндэсний хэмжээнд "бенчмаркинг" хийх чадамж бүхий жишиг үйлдвэр технологийн парк болох зорилго, зорилтод чиглэсэн хөгжлийн стратеги боловсруулах боломж бүрдсэн байна.

## 11.2. Санхүүгийн нөөц

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд орж ирэх орлогын төсөөлөл болон хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зарцуулалтыг хувьчлан тооцлоо.

**Хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх санхүүжилтийн хувь хэмжээний төсөөлөл (4 жилээр)**

| № | Стратегийн хөгжлийн зорилго | 2025 | 2026 | 2027 | 2028 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Паркийн санхүү, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх | 40% | 50% | 60% | 80% |
| 2 | Паркийн дэд бүтцийг хөгжүүлэх, бүсчлэлийг бий болгох | 30% | 50% | 70% | 100% |
| 3 | Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих | 5% | 15% | 25% | 50% |
| 4 | Байгаль орчинд халгүй, ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх | 10% | 30% | 40% | 60% |
| 5 | Гадаад харилцаа хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааг хөгжүүлэх | 15% | 30% | 45% | 60% |

## 11.3. Стратегийн бэлэн байдлын судалгааны тойм

"Налайхын үйлдвэрлэл, технологийн парк"ХК-ийн 2024 оны стратегийн бэлэн байдлын судалгаанд 76,2% удирдах ажилтан, 9,5% мэргэжилтэн, 9,5% бусад ажилтан, 4,8% ИТА оролцсон байна.

Боловсролын түвшингээс харахад бакалавр 57,1%, магистр 23,8%, дипломын дээд 9,5% тус тус эзэлж байна.

Тухайн ААНБ-д 1-5 жил ажилласан 57,1%, 6-10 жил ажилласан 28,6% байхад 16 жилээс дээш ажилласан 9,5 хувийг эзэлж байгааг харахад ажиллах хүчний бүрэлдэхүүн шинээр бүрдэж байна.

Үйлдвэр технологийн паркийн одоогийн эрхэм зорилго, алсын хараа бүрэн тодорхойлогдсон 42,9%, сайжруулах шаардлагатай 42,9%, шинээр тодорхойлох нь зүйтэй 14,3% үзсэн байна. Үйлдвэр технологийн паркийн хамт олон алсын хараа, үнэт зүйл, соёлын чиглэлээр сайжруулалт хийх, шинэчлэх асуудлыг Мексоны 5Х5 шинжилгээнд тулгуурлан шийдвэрлэх боломжтой байна.

Удирдлагын PDCA механизмын үр дүнд тулгуурлан санхүү, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж хуваарилах, ил тод нээлттэй зарцуулах замаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах явдал чухал нөлөөтэй байгаа нь харагдаж байна. Иймд дотоодын чанарын нэгжийн бүтцийг бий болгох асуудлыг СУЗ-р хэлэлцүүлэн дэмжүүлэх нь зүйтэй.

Удирдлагын зүгээс үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагааны чанарыг сайжруулахад эрчим хүч, дулаан, усан хангамжид хөрөнгө оруулалт татах, төр хувийн хэвшлийг холбох чиглэлээр уялдаа холбоог хангах удирдлага, менежментийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Цаашид ҮТП-ийн үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангахуйц хүний нөөцөө төлөвлөх, бүрдүүлэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэн, байнгын сайжруулалт хийх, хүний нөөцийн мэдээллийн сантай, түүнийгээ байнга баяжуулан ашиглах замаар ажилтны ажил үүргийн хуваарилалт, ажлын ачааллыг тооцох, ажилтны орон тоо, ур чадварын шаардлагыг тогтоон, нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, тасралтгүй хөгжлийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэн цалин хөлс, урамшуулал, нийгмийн халамж үйлчилгээний бодлого нь ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүнд суурилсан шударга, уян хатан хэрэгжих тогтолцоотой, байнга шинэчлэгдэн сайжруулах нь чухал байна.

Нийгэм болон хэрэглэгч нарын дунд ҮТП-ийн нэр хүндийг өсгөхөд төр, хувийн хэвшлийн нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ чухлыг гэж үзсэн байна.